

ОХУ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ТӨРИЙН БОДЛОГО, ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙД

*Х.Мандухай**

Хүний хөгжлийг бүх талаар тэтгэх нь Орос улсын төрийн бодлогын нэг гол чиглэл юм. Хүн бүрийн хувийн бүтээлч чанар, боловсрол мэргэжлийн түвшиний дээшлэлт, бие даасан эрх чөлөөт байдалд тулгуурласан төрийн бодлого нь Орос оронд нийгмийн чиг баримжаатай хөгжлийн шинэ хэлбэрт шилжих, түүнийг төлөвшүүлэхэд үнэн чанартаа чиглэж байна гэж хэлж болно. Энэ бодлогыг нийгмийн бүхий л салбарт хэрэгжүүлэх гол хэлбэр нь хүний хөгжлийг хангах зорилтот хөтөлбөр юм. Энэ нь улс орны улс төр, нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамруулан зохицуулах харилцан уялдаатай, үр ашигтай хөгжлийг хангах үзэл баримтлалын стратегийн зорилгоос урган гарч буй аж. Урт хугацааны хэтийн ирээдүйтэй хөгжлийн нийгмийн чиг баримжаа бүхий хэлбэрийг бий болгоход зайлшгүй чухал орчин цагийн институцүүдийн тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай юм. Тийм институцүүдийн тогтолцоо нь дараах чиглэлийн хүрээнд бүрэлдэх аж. Үүнд:

1. Иргэний болон иргэдийн улс төрийн эрхийг хангах, тэрчлэн хууль ёсыг сахихад чиглэсэн улс төр эрхийн институцүүд. Хүний хувийн болон өмчийн халдашгүй эрх, хараат бус шүүх, хууль хамгаалах үр ашигтай тогтолцоо, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөт байдал зэрэг суурь эрхийг хамгаалах зэрэг бүтцүүд орно.
2. Хүний хөгжлийг хангах институцүүд. Үүнд юуны өмнө боловсрол, эрүүл мэнд, тэтгэврийн тогтолцоо, орон сууцны хангамж зэрэг салбарууд хамаарна. Эдгээр салбарын хөгжлийн зангилаа асуудлууд нь тэдгээрийн үйл ажиллагааны шинэ дүрэм журмуудыг боловсруулан институцийн шинэчлэлийг хэрэгжүүлэх явдал юм.
3. Эдийн засгийн институцүүд, өөрөөр хэлвэл, үндэсний эдийн засгийн хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх явдал гэж үзсэн байна. Орчин үеийн эдийн засгийн хууль эрх зүйн үндэс нь эдийн засгийн өсөлт, түүний бүтцийн шинэчлэлийг хангах ёстой аж.
4. Хөгжлийг хангахуйц, хөгжлийн дотоодын системийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, гадаад эрх ашигт нийцсэн төсөв, мөнгөний бодлого, бүтэц, бүс нутаг, нийгмийн бодлогыг уялдуулахад чиглэсэн дээр дурьдсан институцүүдийг зохистой

* Х.Мандухай - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

бүрдүүлэн хөгжүүлэх стратегийн удирдлагын тогтолцоо. Энэхүү тогтолцоо нь институтуудийн өөрчлөн байгуулалтын харилцан уялдаатай хөтөлбөрүүд, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн дунд хугацааны прогнозууд, эдийн засаг, бүс нутгийн зангилаа салбарын хөгжлийн хөтөлбөр, үр дүнгээр нь төсөвлөх санхүүгийн урт хугацааны хөтөлбөр болон сүлжээг багтаахаар тусгажээ. Энэ бүхэн нь хүний хөгжлийн хангаж тэтгэх Оросын төрийн бодлогыг хэрэгжүүлэх гол гол хүчин зүйл болох ёстой аж. Үүний хамт хүний нөөцийн хөгжлийг салбарт институцийн шинжтэй эрс өөрчлөлт хийхээр бас заасан байна. Эдгээр салбарыг хөгжүүлэх, хүргэж буй үйлчилгээний чанарыг сайжруулахад санхүүгийн ихээхэн нөөц хэрэгтэй төдийгүй, давын өмнө үйл ажиллагааных нь үр өгөөжийг эрс дээшлүүлэх шаардлагатай байгааг дурджээ. Хүний нөөцийн хүрээний хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхэд институцийн шинжтэй гүнзгий шинэчлэлгүйгээр хэрэгтэй үр дүн өгөхгүй нь мэдээж юм.

Хүний хөгжлийн стратеги бодлогыг хэрэгжүүлэхэд юуны өмнө мөнгө-зээлийн болон төсвийн бодлогын урт хугацааны чиглэлүүдийн үүрэг холбогдол улам бүр нэмэгдэж байна. Мөнгө-санхүү, төсвийн бодлогын урт хугацааны зорилго нь 2020 он хүртэлх хугацаанд эдийн засгийн өсөлтийн өндөр төвшнийг дэмжиж, дунджаар 106-107 хувь байх зайлшгүй урьдчилсан нөхцлийг бий болгох, макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, макро эдийн засгийн параметруудийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, инфляцийн төвшнийг тууштай бууруулах явдал юм.

Хэрэглээний үнийн өсөлтийн хурдцыг 2015 онд 104,5 хувиас дээшгүй, 2020 онд 103 хувь байлгаж, эдийн засгийг мөнгөөр хангах төвшин /санхүүжилтийн төвшин/ дотоодын нийт бүтээгдэхүүний 65-75 хувьд хүрэх болно.

Урт хугацааны хэтийн төлвийн дагуу эдийн засаг, нийгмийн стратегийн чухал зорилгуудыг шийдвэрлэхэд төсвийн системийн тогтвортой байдлыг хадгалах замаар эдийн засгийн хөгжлийн шинэчлэлийг санхүүгээр хангах хэрэгсэл болсон улсын төсвийн үүрэг дээшилж байна.

2010-2015 оны зааг дахь макро эдийн засгийн тогтворжилтын нэг зангилаа асуудал нь төлбөрийн тэнцлийг өөрчлөх явдал болж байна. Нефтийн болон төмөрлөгийн үнийг үлэмж бууруулсан нөхцөлд корпорациудын өрийг хаах импортын болон төлбөрийн түргэн өсөлт нь 2010 он гэхэд ач холбогдол багатай хүрээнд ч хэдийнээ урсгал үйл ажиллагаагаар үлдэгдэлтэй гаргахаар байгаа нь 2012 он гэхэд худалдааны тэнцлийг үлдэгдэлтэй гаргах бололцоо олгож байна. Харин нефть бүтээгдэхүүний үнэ өндөр хэвээр байгаа нь энэ зааг хугацааг хэдэн жилээр ухрааж, импорт түргэн өсч, экспорт удаан нэмэгдэж буйн

зөрөө нь худалдааны тэнцэл сөрөг үлдэгдэлтэй байсаар байхад зайлшгүй хүргэж байна. /2018-2020 онд худалдааны тэнцлийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5-2 хувьд хүрч өсч мэдэхээр байна/.

Урсгал үйл ажиллагаагаар худалдааны тэнцлийн алдагдал үүсч буй нь рублийн ханшийг бэхжүүлэхэд сөрөг нөлөөлөх нөхцөл бүрдүүлж байна. 2011 оны эцсээр рублийн бодит үр ашигтай ханш тогтворжихоор байгаа юм. Урсгал үйл ажиллагаагаар худалдааны алдагдлыг харьцангуй бууруулж, оросын эдийн засаг, өрнөдийн орнуудын эдийн засгийн орлогын төвшин ойртсоны нөлөөгөөр 2015-2020 онд рублийг ханш сэргэн бэхжиж мэдэх юм гэж онцлон дурджээ.

Үүссэн алдагдлыг урсгал үйл ажиллагааны орлогоор нөхөх явдал нь гадаадын капиталыг өргөн нэвтрүүлж байж хэрэгжинэ. Гадаадын капиталын цэвэр урсгалын хэмжээ хэд дахин өсч болох юм.

Гадаадын капитал урсан орж ирсний ач тусаар урсгал үйл ажиллагаагаар худалдааны тэнцлийн алдагдлыг тэнцвэржүүлэх нь алтан валютын нөөцийн төвшнийг тогтворжуулж болно. Энэ нь үндэсний валютыг чөлөөтэй хөрвөх дэглэмд шилжүүлж, инфляцийн зорилтот үзүүлэлтүүдийг тогтворжуулахад шилжүүлэх нөхцөл бүрдүүлэх үүргийг ОХУ-ын Төв Банкинд ноогдуулсан байна.

Ингэсэн нөхцөлд макро эдийн засгийн бодлогын хүрэх зорилт дараах тэргүүлэх чиглэлүүдээр хэрэгжинэ.

Эхний чиглэл-инфляцыг жилд 3 хувиар бууруулна.

Энэхүү тэргүүлэх чиглэл нь рублийн үр ашигтай солилцох ханшийн тогтворжилтыг дэмжиж, мөнгө-зээлийн уламжлалт бодлого явуулах, төслийн тэнцлийг хангах, тэрчлэн дотоодын зах зээлд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг эрэлтээс түрүүлэнгүй нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг идэвхжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар хэрэгжинэ.

Дэд бүтцийн салбарын бараа, үйлчилгээний үнийн /тарифын/ өсөлтийг хязгаарлахын гол үүрэг нь монополь болоод өрсөлдөөний хүрээнд үнэ бүрдүүлэлтийг зохицуулах үр ашигтай механизм бий болгохын зэрэгцээ, цахилгаан эрчим хүч, төмөр замын тээврийн үйлчилгээний зах зээлийг тууштэй чөлөөлж, эдгээр бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг өргөжүүлэх явдал юм. Энэ бүхэн бол хүний хөгжлийн таатай орчинг бий болгож эрүүлжүүлэх шаардлагаас урган гарч байгааг хүн бүрийн амьжиргааны төвшинг эрс дээшлүүлэх талаарх зорилтот хөтөлбөрт онцлон тэмдэглэсэн байна.

Нөгөөтэйгүүр дэд бүтцийн болон институцийн аливаа хязгаарлалтыг устгах, эдийн засгийн хөгжлийн шинэчлэл хийх, хүн амын амьдралын төвшин, чанарыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэхэд улсаас гаргах зардлыг нэмэгдүүлэх явдал юм гэж заасан байна.

Нийгмийн чиг баримжаатай хөгжлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогод харшилж буй голлох бодит зардлын сүлжээ нь орчин үед улам нарийсч буй төсвийн системийн бүтцийн зардлыг өөрчлөхөд голлох үүрэгтэй юм. Хөгжлийн зорилтот чиг баримжаанд хүрэхийн тулд боловсрол, эрүүлийг хамгаалах, соёлын салбарын зардлыг багтаан зохиосон төсвийг өсгөн нэмэгдүүлэх, үүний зэрэгцээ эдгээр салбарын үйлчилгээг санхүүжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох нь чухал юм байна. Хүний чадамжийг хөгжүүлэхэд чиглэсэн төсвийн системийн зардал 2007 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 8,6% болж байсан бол 2020 онд энэ хэмжээ 11-11,7 хувь болж өсөх ёстой аж.

Оросын эдийн засгийг орчин үеийн болгох, дэд бүтцийн хязгаарлалтыг арилгахад дотоодын нийт бүтээгдэхүүний дөрвөөс багагүй хувь нь улсын хөрөнгө оруулалт байх хэмжээнд дэмжихийг шаардаж байна гэж онцолжээ. Хөрөнгө оруулалтын үндсэн хэсгийг дэд бүтцийг, давын өмнө авто тээвэр, эрчим хүчний дэд бүтцийг хөгжүүлэх, түүний дотор хувийн болон төрийн өмчийн түншлэлийн механизмыг ашиглахад зориулах аж. Үүний зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхийн тулд нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм байна.

Шинжлэх ухаан-техникийн баазын шинэчлэлийг дэмжихийн тулд 2008 онд нийгмийн нийт бүтээгдэхүүний 0,7% болсон бөгөөд 2020 онд 1,3 хувь болж нэмэгдэх суурь болон хавсарга судалгаанд зориулсан улсын төсвийн зардлыг нэмэгдүүлэхийг шаардаж байна.

Бүхэлдээ хөгжлийн төсөв буюу шинэчлэлийн төсөв /боловсрол, эрүүлийг хамгаалах, суурь болон хавсарга судалгаанд зориулсан зардал, авто тээвэр, нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг оролцуулан/ нь хэдийгээр авто тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх улсын хөрөнгө оруулалт харьцангуй буурах боловч 2015 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 14% орчим, 2020 онд 14,2-15% хүрнэ гэж хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрт чухалчлан тэмдэглэсэн байна.

Ашигласан материал

1. <http://russian.people.com.cn/>
2. <http://kremlin.ru/by-region/MOS>
3. <http://rian.ru/politics/>